

Онгодын нэхэл үг угсаатны түүх, соёлын
онцлогийг тусгадаг болох нь

С.Дулам*

Бөөгийн онгод орохдоо хэлдэг нэхэл үгийг угсаатны зүй, соёл, түүхийн үүднээс судалбал ихээхэн сонирхолтой байж болох юм. Онгод ороод ихэвчлэн хаан амраа амарчилж хатан мэндээ мэндчилсний дараагаар бөө мөргөлийн аман яруу найргийн нэгэн төрөл зүйл болох онгодын нэхэл үг орж ирдэг. Өөрөөр хэлбэл, Онгодын нэхэл үг гэдэг бол мэндийн үгний үргэлжлэл шинжтэй байна.¹

Онгодын нэхэл үгний олонхи нь цайны нэхэл үг байгаа нь монгол хүн гаднаас ирсэн зочиндоо хамгаас түрүүнд цай аягалж өгч цайлдаг тэр ёс заншилтай холбоотой. Дархад шарнууд бөөгийн онгод “*аагтай шаргал цайныхаа дээжийг ууя*” гэнэ. Буриад бөөгийн онгод “*шандаганые шавардам / шара улаан сайные дээжий тэнээ амснам даа*” (хорь буриад бөөгийн онгод), эсвэл “*шанагы тэнээ гозоймо шара улаан сайеы тэнээ уунам даа*” (хударь буриадын онгод), “*шаргал улаан сайгаа бахархаж хүртье л*” гэдэг бол амт муутай, шингэн цайг “*сэхэр сагаан сийдэм*” гэж голдог байна. Тэд бол ааг амт ихтэй, өтгөн улаан шаргал цайг уудаг байсан болохоор “*шингэн сайе амсаагүүб*” хэмээн өчиглөж байдаг. Монгол туульст бол үүнийг “*уураг болсон улаан шаргал цай*” гэхчлэн өгүүлдэг нь угтаа нэгэн утга чанартай зүйл болно.

Тамхиар тамхилах тухайд энэ нь үүссэн цагаасаа мэнд усаа мэдэлцэх нэгэн зүйл арга хэрэгсэл байсан тухай судлаачид онож тэмдэглэжээ. Тухайлбал, шарнууд овгийн сүлд болсон Цагаадай бөөгийн Цанхилан хатан орж ирээд:

*Богдо эзэн хааны
Босоо цагаан хуягууд
Бүгүдэ амур мэндэ вайнуу?*

* Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, Соёлын Сургууль

¹ Д.Бум-Очир, *Монгол бөөгийн зан үйл*: Аман яруу найргийн төрөл зүйлс. Улаанбаатар, 2002, 265 т.х.

Бичихан бүжин зулзаганууд
 Бүгүдэ бүрим мэндэ вайнуу?
Мэндийн шара тамиххи аваад ирээ!
 Хараха нүдмини харалгам болжи,
 Шүллүсүмини арамжаа (аргамжаа) болжи,
 Нуссүмини бурунтаг болжи!
 Арийн аавийн күүхүд,
 Сонин сайхан йуу вайна?

Улус: - Юүүчигүү, тайван сайхан вайна. Танайхаар сонин йуутайвээ?

Цанхилан: - Юмгүү, тайван мэндэ вайна. Хөкшим болсом би, йуучи мэдэхкүү.
 Уг үндүсү, ясу уксаагаал дагажси ингэжси ганхажси ёвуна.
Хөкшим буурул эжичини идэхү йүм йуу вайна гэжси ёвуна хүүхүд-мини!

Улус идээ варижси, цай, ариххи хийжси өргөдөг. Идээ хүндийни токтоогаат Цанхилан хатан:

Дайражси ирэхэдэмини далайшиг
 Буууж ирэхэдэмили
 Булукишиг оргилжси суугаарактуу!
 Үр төлээр байалик
 Үрээ мориор таргун
 Талбиун суухийн йөрөөл
 Тавижси буций!²

гэхчлэн өөд болдог тухай Хөвсгөл аймгийн Бүрэн сумын Сандуугийн Цэвэгдорж удган хуучилжээ. Тэгэхлээр нэг зуун хорин настай, зургаадай модон таяг тулсан их өтгөс эмгэний дүртэй энэ онгод маань “жанч шашир өмсөөгүй байхад” буюу Монгол оронд бурханы шашин дэлгэрээгүй байх их эрт цагийн онгод бөгөөд өөрийн өгөл насны тухайд уран хошин үгээр “харах нүд минь харалган болж, шүлс минь аргамжаа болж, нус минь бурунтаг болж” гэхчлэн өгүүлж, бас өөрийн удам угсааны хойчисыг “бяцхан бүжин зулзаганууд” гэхчлэн өхөөрдөн дуудаж буй нь сонирхолтой.

Энэ их өтгөс онгод маань идэх үүх юмнаас түрүүн “мэндийн шар тамхи” нэхэж буй билээ. **Тамхилна гэдэг нь угтаа бие биедээ хар муу юм саналцаагүй, өөр зууртаа эвтэй найртай, сайн сайхан явалцаж байгаагийн илэрхийлэл, бас хөөрөг, гаанс солилцдог нь бие биедээ эд эрдэнэсийн зүйлсийг өгч авалцаж буйн бэлгэдэл болдог.** Монголчууд хөөрөг, гаансаа аль болох үнэтэй цэнтэй эрдэнэсээр урлах, урлуулах хэмээдэг нь анх гарлаасаа бол бие биедээ баян тарганаа гайхуулах гэхээсээ илүүтэй энэхүү бэлгэдлийн утга учиртай нь холбоотой байжээ. Дээрх жишээнээс үзвэл, залран ирсэн онгод идээ ундааг нь зооглож, мэнд хүндийг нь мэдсэний дараа удам хойчистоо зориулан “дайраад ирэхэд далай шиг буцаад ирэхэд булаг шиг” гэхчлэнгийн өлзий бэлгэтэй эрхэм сайхан үгсийг хэлж дээшээ дэгдэн залардаг байжээ.

² Rintchen B. *Les matériaux pour l'étude du chamanisme mongol*. III. Textes chamanistes mongols. Wiesbaden: Otto Harrassowitz, 1975, 151 p. [Asiatische Forschungen, Band 40]

Бидний бодлоор чухам энэхүү “*дайраад ирэхэд далай шиг буцаад ирэхэд булаг шиг*” гэсэн ерөөл бэлгийн үгс маань үр хойчдоо үе үе залран ирж бууж байдаг онгод шүтээний хэлмэр үг байсан гэлтэй байна.

Үүний нэгэн адил дархад шарнууд Чойдашийн Батбаяр удганд ордог зарим онгодууд ч мөн нэгэн адил “*Мэндийн улаанаа угзарья (баагуулья)*” хэмээн нэхэж байдаг.³ Улаан тамхи буюу “улаан дүнс”⁴ гэдэг нь монголчууд өнөө болтол татаж хэрэглэсээр байгаа орос дүнсэн тамхины нэрийдэл болно. Энэ бол монгол үлгэр, туульст гардаг “галзуу улаан тамхиа ганц хоёр шившээд” гэдгийн хожмын нэгэн хувилбар мөн билээ.

Мөн дархад бөөгийн онгодууд “*Тайван /Дайван/ хааны ногооноо⁵ татъя*” гэж нэхдэг нь XIX зууны үесээс Мүгдэн (Шэньян), Харбинд үйлдвэрлэж байсан боодлыг задлахад дээр нь арц тавиастай байдаг, угтаа арцны хольцтой, үргэлж чийглэг нойтон байдаг тул цаасанд ороож татах боломжгүй заавал гаансанд татдаг хятад ногоон дүнсэн тамхийг хэлж байгаа хэрэг.

Харин зарим буриад бөөгийн онгод “*манжуур сигэрээт татая л даа*” гэдэг нь XIX зууны сүүл үесээс их хэрэглэж байсан хоёр зүйлийн янжуурын нэр хэмээн манж хэлний багш асан өтгөс Я.Шаарийбуу авгай бээр бидэнд мэдээлэв. Үүний нэг нь “Харбин хотын их хаалга” (ha da men)⁶ нэрээр алдаршсан, гашуун биш, цэвэрхэн, зөөлхөн амттай “Хадамин янжуур”, мөн нөгөөх нь Бээжингийн “Урд хаалга”-Чаминд (qian men) хийдэг байсан “Чамин янжуур” гэлцэж амтархан татдаг, түүнийг ч бас “манжуур сигэрээт” гэдэг байсан байна. Энэ хоёр тамхи нь өдгөөх зонд нэгэнт үгүй тул орчин цагийн хүмүүсийн татдаг янжуурыг асааж өгөхөд “*үбхэн соорхон адали*” (өвс цоор шиг амтгүй юм) гэж ихэд голдог бөгөөд “*манжуур сигэрээт, гээшимнай манай эндэ үгүйбдээ, оршоожо хайрла бурхашуул*” гэж аргадан тайтгаруулж сая номхон дөлгөөн болгодог билээ.

Дархад хуулар юм уу духа цаатны онгод голдуу хаксуурганд (Хөвсгөлийн хөвч тайгад ургадаг нэгэн зүйл голоороо нүхтэй модоор урласан гаанс) нэрсэн тамхи нэхдэг бөгөөд дархад, цаатан бөө нэр урьдаас урлаад бэлдчихсэн ийм гаанстай байдаг байна.

³ Шарнууд овогт Чойдашийн Батбаяр удганаас Д.Бум-Очир тэмдэглэн авчээ /Улаанбаатар, 2000 оны 1 сарын 8/

⁴ “Düngse” гэдэг нь гаансаар татдаг, нарийхан хэрчиж хатаасан тосорхог тамхи [Norjin Č., Mören Mang. Mongyol kelen- ü toli. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1999, 3142, 2661].

Мөн халуун дулаан оронд ургадаг, том том хавтгай улаан навчин тамхи байдаг бөгөөд толгойн өвчин намдаадаг, цусанд сайн болохоор нь настай улс голдуу татдаг, их хатуу амттай “ээзиян” хэмээх навчин тамхи бас байсан гэнэ (МУИС-ийн манж хэлний багш асан, 1909 онд төрсөн, цагаан нохой жилтэй гал галзууд омогтой Я.Шаарийбуу багшаас бичиж авав).

⁵ “Тайван хаан” гэдэг нь “Тайпин хаан” (tai ping) буюу Манж Чин улсын Энх-Амгалан хааныг хэлсэн бололтой. Мөн “Тэмээний даллага” зэрэг монгол аман зохиолын зүйлд “Өмнө этгээдийн Далай Тайван хааны газраас алт мөнгө, эд агуурсны хутгийг гуйнам” [ЗҮАЗ 1987, 40] гэхчлэн өгүүлдэг нь мөн л Манж Чин улсын Энх-Амгалан хааныг хэлсэн бололтой.

⁶ МУИС-ийн манж хэлний багш асан, 1909 онд төрсөн, цагаан нохой жилтэй, гал галзууд омогтой Я.Шаарийбуу багшийн мэдээлснээр “Хадамин янжуур” (ha da men) нь цагаан эрээн хатуу хайрцагтай, бага нь дотроо арван ширхэгтэй, том нь дотроо хорин ширхэгтэй тамхи байсан гэнэ. “Чамин янжуур” (qian men) нь зөөлөн улаан гэртэй дотроо арван ширхэгтэй, Бээжингийн Чамин хаалганы (qian men) зурагтай янжуур байжээ.

Харин буриад онгодууд (Мармааны хүбүүн Хулхуу их заарин, Авгалдай онгод) бол “үндэһэн модон трүпкэд улаан тамхиа татах минээ гүү / бааюулах минээ гүү” хэмээн нэхдэг бөгөөд “үндэһэн модон трүпкэ” гэдэг нь Монгол газар хаа сайгүй ургадаг бүйлсний иш үндсээр голдуу хийдэг бөгөөд хагардаггүй, цуурдаггүй, бөх хатуу мод болно. Онгод ч өөрсдөө “бүйлээһэнэй үндэһэн трүпкэд мангад шара тамхиа татдаг билээ, бүйлээһэнэй үндэһэн адха дүүрэн алаг эрээн шара ... байдаг билээ” гэхчлэн хуучилж байна. Онгодыг тамхи нэхэхэд нь орчин үеийн шүүлтүүртэй янжуур асаан өгвөл, шүүлтүүрийг нь “энэ юун гээшиг” хэмээн мултлан авч хаядаг тохиолдол байдаг.

Монгол угсаатны бөөгийн онгодууд аагтай, амттай, улаан шаргал цай, орос, хятад, улаан, ногоон дүнсэн тамхи нэхэхээс гадна архи сархадын дээжийг нэхэж уудаг. Архи гэхэд “шимийн барааныг шимэлгэе” (дархад шарнууд) гэвэл монгол угсаатны үнээний сүү, гүүний айргаар нэрдэг сүүний (саалийн) архи буюу шимийн архи, “хатуу харын дээж”, “хатан хар нанчид” гэвэл үйлдвэрийн аргаар дахин нэрлэгээр нэрж гаргасан хатуу сархад, “хатан барааны дээж” гэвэл аль аль нь байх жишээтэй.

Дархад бөө нэрт ордог буриадын эзэн Буха Илдэн баатар хариадын эзэн Хара Илдэн баатар хүрч ирэхдээ бух мэт урамдаад олны зүг: “Мэндэ сайн байнуу, арийн аавийн хүүхэд мини” гэхэд “Мэндэ сайн байнаа! Буха Илдэн ааваар сонин сайхан йуутайв” гэхэд “Йумгүээ, тайван сайхан байналдаа. Эзаалда, заалда! Танай газар йуу зугаалажи байна, хүүхэд багачуул мини? Идэхэ үуху амтатан, хатан хар нанчид бэлдэв үү? Уугаад идэх л гэжи ирэлээ, Буха Илдэн чини! Ганзаа үүх сайхан байна! Өвгөд түшмэд бүгдээрээ найралцагая. Ганзаа үүжи ганхацагая! Ай, Эзаалдамар, заалдамар! Ганзайгийчини йааж зүгээр үухув?”

*Найман Намсарайшиг байан
Найдан жүддүгишг өнөр
Сууцагаактуй, багачууд мини!
Заа! Буриадынчини эзэн Буха Илдэн
Хариадынчини эзэн Хара Илдэн баатар
Харийаа, харийаа!⁸*

хэмээн онгод нь өөд болдог байна⁹. Энд гарч байгаа ганзай буюу ганжуу¹⁰ гэгч архи нь XIX зууны эцэс, XX зууны эхээр Монгол оронд хэрэглэж байсан, шар будааны архины дахин нэрлэгээс (арз болгон) гаргаж авсан хатуу хар архины нэрийдэл болно. “Баян хангайн бараа” хэмээх барга ардын дуунд:

*Ганзай уулын сэсэг (цэцэг) нь
Гандах биш хүхэрнэ (хөхөрнө)*

⁷ “Эзнээ алда, эзнээ алдамар” гэсэн хараах үгийг ярианы хэлэнд ийн хэлдэг.

⁸ Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. III. Textes chamanistes mongols. Wiesbaden: Otto Harrassowitz, 1975, 76-78 p. [Asiatische Forschungen, Band 40]

⁹ Хөвсгөл аймгийн Бүрэн сумын 9-р багийн ард, зургаан үеийн удган Сандуугийн Цэвэгдоржоос (50 настай) 1954 онд Б.Ринчен багштан тэмдэглэж авчээ

¹⁰ Я.Шаарийбуу багшийн мэдээлснээр хятадын архины пүүсэнд (шоогуул) том саванд нэрээтэй байдаг, худалдан авагч өөрөө саваа барьж очоод хийлгэж авдаг, тусгайлсан шилгүй, 40 гаруй хэмтэй хатуу архи байжээ.

Ганихарч байгаа сэтгэлийг
Ганзай дарсаар хуурья даа¹¹

хэмээн дуулдаг янаг амрагийн уянгын дуу байдаг бол мөн “Мээжээ гуай” хэмээх шинэ баргын нэгэн шог дуунд:

Ганжуу нэртэй (нэртэй) архинд
Ганхаж байнууч Мээжээ гуай
Ганжуур ширээтийн буянд
Галзуурч байнууч Мээжээ гуай¹²

гэхчлэн архинд толгойгоо мэдүүлсэн нэгнийг сурган шүүмжилсэн байдаг.

Харин хорь буриадын галзууд омогт, заарин Чойжилын Цэрэн баавайд ордог онгодууд ихэвчлэн “Хатуухарайн дээжийе тэнээ ууя/амса” хэмээн нэхэх бөгөөд ингэхэд тулмаашаас “Хатуу харайн дээжийе барийтээ, бурхашуул” хэмээн хоёр гардан толгой мэхийн их хүндэтгэлтэйгээр өгч байна. Гэтэл худари буриадаас гаралтай, дурдалгад өгүүлснээр “ерэн долоон наһатай, наян хоёр наадамтай, загаһанай миханда садаагүээ” Сэвэгийн хүвүүн Балдахов (Балдаков) гэгч онгод орчин цагийн хүн зоны хэрэглэж байгаа цагаан архи хийж барихад:

Ха ха ха (инээж)
Охи л мэт хатуухан
Ямар архи өгөм та
Бүхэ сагаан бүрхээрдэм
Бүхэтэр голоон шоргуулан
Хүлэр наймы: танхаар гараһан
Архи биш байнам даа

хэмээн гайхан асууж сураглаж байдаг. Өөрөөр хэлбэл, тэр онгодын хүмүүн явах цагтаа амсаж шимшиж байсан, “бөх цагаан бүрхээрт бөгтөр гол шургуулан” том хэмжээний хүрэл танханд нэрж гаргасан архи биш байна хэмээн лавлан маргаж байгаа юм. Ингэхэд

Тулмаашаас: *Бишээ биш! Монгол орной мэнэ үйлэдбүрээн сагаан архи гээшэ байнав даа.*

хэмээн тайлбарлахад:

Онгод: *Үйлэдбүрээ гээшийе тэнээ мэднэ гүүб дээ. Ямар юма байнам?*
Тулмааш: *Улаан буудайгаар хийсэн монгол архи.*
Онгод: *Улаан буудай гээшэ-нэ юун бэ?*
Тулмааш: *Пишиниис гээшэ талд ургадаг тариан болха.*
Онгод: *Мэднэ гүү яахам даа, тэр тариан тарьдаг нутаг нь...*
Тулмааш: *Монгол орной хойто талайн Орхон, Сэлэнгэ мөрнэй хөвөөн газраар л*

¹¹ Д.Сэндэр, Барга ардын дуу. Эмхтгэн найруулж, ариутган шүүсэн Л.Гомбо, Г.Ариунчимэг, Улаанбаатар, 2004, 98т. х.

¹² МУИС-ийн манж хэлний багш асан, 1909 онд төрсөн, цагаан нохой жилтэй, гал галзууд омогтой Я.Шаарийбуу багшийн мэдээлснээр Баргын улаан Ганжуур сүмийн ширээт ламын ач (дүүгийн хүү) Мэнд (Мээжээ) гэгчийг архинд толгойгоо мэдүүлж явааг нь шоолон элэглэсэн дуу болно.

тарих л даа.
 Онгод: Хоолой *хаһа зураһан хатуу архи гардаг һаам даа*
 Тулмааш: *Тийм ээ, тийм, хатуу архи.*
 Онгод: *Ха. ха, ха Бүгдээ мэндэ амар һуугтий даа, ябадал*
*мэнээ яаралтайм даа, хэрэг минээ хэмжээлтэйм дээ*¹³

гэхчлэн нэлээд яриан хөөрөөн, асуулга хариулга болж, учирлан тайлбарлаж өгдөг. Үүнээс үзвэл, Байгал нуурын Качуг районы худари бөөгийн хуучин цагийн онгод одоо цагийн халх Монгол нутаг болон эндэхийн тариалан орон, тарьдаг ургамал, түүнээс нэрж гаргадаг архины тухай тун хомсхон төсөөлөлтэй байх нь аргагүй билээ. **Энд хамгаас сонирхолтой нь янз бүрийн цаг үеийн, янз бүрийн газар орны хүн зоны уулзалт буюу цаг хугацаа, орон зайн огтлолцол болж буйгаараа нэн гайхалтай бөгөөд үүгээрээ урьд нэгэн цагт өөрсдийн бодтой оршин байсан гэдгээ таниулж мэдүүлж байгаа хэрэг хэмээн үздэг.**

Гэтэл горлос бөөгийн онгод бууж ирээд “па пу” хэмээн гадагш үлээвэл хүйтэн ус өгдөг, “пол, пол” гэж дуугарвал гаанстай тамхи ноцоож өгдөг байна”.¹⁴ Энэ мэтчилэн архи, цай, тамхи гурвыг нэхэх нь тун элбэг бөгөөд ер нь аль ч зүйлийг өглөө гэсэн шовширч шивширч байж (бөөгийн) аманд нь зуулгадаг.

Монгол угсаатны бөөгийн онгодууд тухайн угсаатны эрхэлдэг аж ахуйн онцлогийг илтгэсэн бусад идээ ундаа, эд зүйлсийг ч нэхэж шавдуулж байдаг. Баргужин нутгийн гулбаа явсан һамнай Сахаровын басаган Одон цагаан хатагтай гэгч Халхын буриад бөөгийн онгодоод орохдоо:

Загаһаны михан амтатан минь
Гоёһоноор шараһан михан
Амт гээшэ нь жигтэйхэн
Мангир даваһы нь тааруулаад
Хажуу дахь хүндээ өгөмгүүм дээ
Өргөн далайн хишиг минь ээ
Байгал далайн буян минь ээ
Оймоло загаһан идье л дээ

хэмээн мангираар амтлан шарсан омуль (булуусхай) загас хүртэл нэхэж байдаг. Хариуд нь тулмааш “Энд минь ээ тийм юм байхгүй л дээ. Хатан авгай минь өршөөж хайрла” хэмээн өчихөд онгод “үргэн мурэн үгүйм тээ”¹⁵ хэмээн асууж сураглаж байдаг.

Ийнхүү гагц буриад зоны дунд л гэхэд Ага, Хорийн буриад бөөгийн ёс заншил, худари буриад бөөгийн ёс заншил өөр хоорондоо тэс ондоон байдаг байна. Хэдэн жилийн өмнө

¹³ 1995 оны 6-р сарын 13-нд Хэнтий аймгийн Батширээт сумын харъяат худари буриадын хэнгэлдэр омогтой Улаадай Доржийн хувүүн Баярын дээдэс Сэвэгийн хувүүн Балдахов (Балдаков) гэгч онгод галзууд омогт Ч.Цэрэн зааринд бууж ирээд ийнхүү хуучилсан билээ (Дорнод аймаг, Баян-Уул сумын Хархираа хэмээх газар Д.Бум-Очирын хамт соронзон хальсанд буулган авав)

¹⁴ Kürelša, Bai Zui-ing, Način, Buyančuyla. Qorčin böge mörgül-ün sudulul. Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 1988, 620 p.

¹⁵ Дорнод аймаг, Баян-Уул сумын харъяат, дагаанхан галзууд омогт Чойжилын Цэрэн заарин, хуацай омогт Цэвэгдоржийн Базар заарингийн тав зургаа дахь чанарыг удирдан хийлгэж байх үеэр “Хархираа” хэмээх газар 1995 оны 6-р сард Д.Бум-Очирын хамт дүрс бичлэг, соронзон хальсанд буулган авав.

худари буриад гаралтай Ехэ Шонод омгийн (хараагүй) бөө, Майдарын Жавхлангийн эхний хоёр чанар нь бүтэхгүй байсны цаад учир нь энэ бөөгийн уг гарбали Хэлмэн заарин бол есөн дэрвэлгэдээ (юһэн дэрбэлгэ) омуль загас (оймоло загаһан) өлгүүлж, шинэсэн ширээн дээр цурхай загас өргүүлж, галзуу бөртэ буюу чоно унуулж бөөлүүлдэг зан датхалтай юмсанж. Бас Далайн эзэн Далжир хара ноёны хатан Балжир хатанд зориулж, чанарын ёслолын зүүн хойт биед нь шинэсэн ширээн (шинэнэн шэрээ) дээр хоёр улайдмал чулуунд хавчуулан болгосон омуль загас өргөж дуудах ийм ийм учир түүхтэй юм байна. Гэтэл Ага, Хорийн буриад бөөгийн ёс заншлаар хонин шүүс, цагаан идээн өргөл өргөсөн маань ийм өргөл хүндлэлийг уг гарбали нь хүлээн авдаггүйгээс болоод чанарын ёслол, бөөгийн хэрэг нь бүтэж бүрэлдээгүй байна.

Энэ бүхнээс үзвэл “бөө бөөгийн бөөлөх ондоон, бөжин туулайн шогших ондоон” гэдэг ёсоор буриад нэр зүүсэн л бол бүх зан үйл, ёс ёслол нь тав яв гэтэл таарч байх албагүй гэдэг нь тодорхой байна. Халх, хотгойд, дархад бөөгийн онгод бол “*хэлээб талхан идье л дээ*”, “*гушан хоёроо /хозор/ хулуудъя*”, “*мангад хаваас уух мэнээ гүү*” хэмээн нэхэх зан заншил огтхон ч үгүй билээ. Өөрийгөө Читийн думын ноён гулбаа явсан хэмээн таниулдаг Баян цагаан Айралжины эзэн Хуандай ноён буюу Зүлхэ заарин бол “гушан хоёроо хулуудъя” гэх жишээтэй нь мөрийтэй наадамчдын “баруун зүүн мөрийг, гарыг түшсэн” аз хийморь ивээн тэтгэгч болохыг илтгэнэ. ***Энэ бүхнээс үзэхэд монгол угсаатны бөө мөргөл нь угсаатны бөлөг тус бүрийн идээшин дассан байгаль газарзүйн онцлог, эрхэлж ирсэн аж ахуй, соёл, зан заншилтайгаа ямаршуу ургамал нарийн холбоотой гэдэг нь мэдэгдэж байна.***

Мөн Чойжилын Цэрэн зааринд ордог Болод бумали гэдэг онгод:

Булагайн уһан умдаа мэнээ
Алтан шорой... мэнээ
Хара булгайн уһыгээ
Амсажа л ууъя л даа

хэмээн нэхэхэд тулмааш аяганд шороо хийж дээрээс нь ус хийн онгодод өргөн барьж байдаг. Тухайн үедээ залгилан ууж байвч онгод гарсан хойно “юун их шороо залгиулчихав” хэмээн тамшаалан тургиж байсан билээ.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын хар дархад овогт Тувааны Балжир удганы онгод олон хөлийн газраас хүн амьтан ирж бөөлүүлэх үед “*хангайн хар усыг аваад ирээрэй хүүхдүүдээ*” гэхчлэн цэвэр тунгалаг булгийн ус нэхэж байдгийг удган маань тайлбарлахдаа үхээрийн бузар ихтэй газраас олон хүн ирэхлээр үхлийн хар будан манараад байдаг учир хээрийн зэрлэг онгод ариун асар тэнгэрээсээ шууд дунд нь бууж ирэх дургүй байдаг тул булгийн цэвэр тунгалаг рашаанаар манараад байгаа хар тоосыг дарж замаа засч ариутгах учиртай болдог гэсэн билээ.

Түүнчлэн Хулхуугийн хувүүн Буха заарин идээ ундааны зүйлээс “*Алаг бөөртэй тугалы тэнээ амалуулжа хөхүүлэжэ хааһан амтата һайһан һүүгээ хөөрүүлж хөшөөгөөд өрмий нь аваад бүрэнэн элэгэн таргы тэнээ ууъя л даа*” хэмээн хуучин цагийн монгол хүмүүний ёсоор нэхэхэд “*мүнээ тиймийма үгээ л дээ*” гэж тулмааш айлтгахад “*хүхэ ногоо ургажа*

хүхээ шубуун донгодоод зунай нара гараад айхада хүүн хаали үгээ хууха гээшимнай юун гээшэбтэ” гэхчлэн ихэд хилэгнэн донгоддог билээ. Ингэхэд нь олон зоноос “ган болоод хура бороон оронгүээ модо мэт хатажа, могой мэтэ зулмажа байнабди” хэмээн арга учраа тоочиж, зовлон зүдгүүрээ өчиглөвөл сая уур хилэн нь арай чарай намждаг билээ.

Улаан хуулар овгийн Дамдингийн Батчулуун удганд¹⁶ орж ирсэн Чингэлтэйн ээж буюу Ягаан удган хэмээх онгод орж ирэхдээ жимс, жимсгэний чанамал голдуу нэхдэг бол Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын харьяат, цагаан хуулар овгийн Баярын Урхөөрөг удганд “Төмсчин ээж” гэдэг онгод орж ирэхээрээ уулын цагаан төмс идэх хүсэлтэйгээ өчдөг. Урьд “Төмсчин ээж” онгод нь амьд ахуй хүн явах цагтаа олон нялх нойтон хүүхэдтэй ядуу зүдүү нэгэн байсан төдийгүй, тэрбээр хүүхдүүдээ уулын цагаан төмсөөр тэжээж өсгөсөн тухай хууч яриа байдаг. Тиймээс ч “Төмсчин ээж” онгод улаач бөөд орж ирэхээрээ урьдын амьдралын дадал хэвшил болсон зүйл болох уулын цагаан төмс нэхдэг байна.

Онгодын нэхэл үг нь дан гагц идээ ундааны зүйлээр хязгаарлагдах биш, амьд ахуй цагтаа эдэлж хэрэглэж байсан эд өлгийн зүйлээ бас нэхдэг учиртай. Энэ талаар нэгэн сонирхолтой баримт дурдахад 1995 оны зургадугаар сарын дундуур галзууд омгийн Чойжилын Цэрэн заарингаас найжи (багш) болон хөтөлсөн хуацай омгийн бөө Цэдэвдоржийн Базар гуайн “тээли шанар” буюу тав, зургадугаар чанарын үеэр хорь буриадын хуацай омогт Модоон удган онгодод орохдоо:

*Хаан солдо дийлдээгүй
Гомбойн хүүгэн Модоон би
Эзэн хаанда дийлдээгүй
Эрх дураараам Модоон би*

гэхчлэн тамлан бууж ирсэн бөгөөд тэнд байгсдаас “үхэрээн эвэр болмоо мэнээ байна гүү” хэмээн нэхэж, булт олныг гайхан алмайрахад хүргэсэн бөгөөд төдөлгүй ихэд хөхин баясч, чангаар инээн дамшиглаж байсан билээ. Бүр цаашилбал, Модоон удган “ширээдхэнэй” (гагнуурын ширээдэс) улаан согые асааж өгөгти” хэмээн нэхэж гараа хооронд нь үрэхэд галч түлээчнийг дуудан хус модны бүрэн шатсан бөмбөгөр улаан цог авчирч гар дээр нь тавихад хоёр алгандаа атгалан хэмхэлж, гар нүүрээ ухиах байдлаар үрчсэн билээ¹⁷. Ийн аашилсаны учрыг Ч.Цэрэн заарингийн тайлбарласнаар бол бид урд өдөр нь Модоон удганы адуу мал хөөдөг “сайн эр” явсан болон арггүй баригдан шүүгдэхийн цагт их гал түлж шатаахад шатсан нурман доороос хуяг хувцастай хэцээ дэлдэн дүүлэн хөөрсөн гэх бөгөөд ийм учраар хаан төрд дийлдээгүй халуун галд шатаагүй дархан удган болсон гэдэг.

Энэ түүх домгийг ярьж байх үед надаас эхлээд хэн хүнгүй, “галд шатдаггүй хүн гэж хэн байх вэ дээ, энэ ч ёстой домог л юм даа” гэж үл итгэн бодож байсан нь гарцаагүй. Бидний үл итгэх байдлыг одоо нүдэнд үзүүлэн батлахын тул ийн хусны улаан цог авчруулан олон түмний өмнө гар нүүрээ булхан угаасан хэрэг. Модоон удганы алдартай түүх домгоос сонирхуулбал: “Модоон

¹⁶ Батчулуун удган бол улаан хуулар овгийн заарин Жамбын Дамдингийн охин бөгөөд түүний ээж нь Ягаан удган болно.

¹⁷ Харамсалтай нь яг энэ гайхалтай мөчид манай зураглаач, дурангаа өөр тийш нь далийлгаад өөрөө ангайн ширтэж байснаас болоод бүрэн бүтэн зургийг нь авч чадалгүй, хагас хугасхан зураг авсан билээ.

удаган залуу басаган ябан гэхэдээ эрэ хүнэй хубсахан үмдөөд, үхэрээн эбэр (“бомбоо” болгож) нүхэлэж шээгээд *Ара Халхайн Заяа Бандидай нутагһаа адуу хөөжө ядар зондо тараагша байба ха. Ара Халхайн Заяа Бандидай адууе бөөм бөөнөөр хөөгөөд, жасайн хүргийе хооһолохоёо хүрбэ гэхэ. Шэнжээшээр шэнжүүлэхэдэ-нэ хүлээн гэхихэдэл-нэ эмэ хүнэй шэнжэтэй гэхэ. Тэрэ сагай эмэ хун хулагай хэхийе мэдэхэгүээ. Заяа бандида энэнэ-хаа мангадай хулгайшан гэжэ мэдээд отожо барюулахада эмэ хүм илэрэжэ байба ха: Эзэнээ хотодо хүргэжэ ерээд хилэ дабуулажа хулагай хэһэн гэжэ саазалан хороохо шидхэбэритэй болообо. Тийхэдээ амитай, оргойтой-но шатааха гэжэ. “Тийхэ дуратайһаа тийхэ” гэлсээд Эзэнээ хотодо түүрмээ хашаан соо олон ноёд хаража байжа шатааба гэхэ. Шатаад обогор улаан сог боложо байтараа мангад ноёдууд “Модооихо пропала” гэлдэжэ байжа. Гэнтэ обогор улаан сог хүдэлжэ шэлгээгээд, Модоон удаган амитай оргойтойёон хамаг юума-на сантаһан амида хэбээр бодожо ерээл- даа. Тийгээд “тий-тий, дааража байнав, галаан засагтий ноёд” гэжэ хэлэхэдэ-нэ олон ноёд ехээр айдаһан хүрээжэ “шамайе дархалба, пажсааласта” гэлдэбэ гэхэ. Модоон удаганһаа Хулхуу аавайн саада уг болхо. Зарим үгэдэ онго орохоһаа “шэрээдһэнэй улаан гал асарагтий” гээд модоной согоор нюур гараа угаажэ аашалха. Баһа “үхэрээн эбэр бомбоо мэнээ асарагтий” гэжэ аашал-хоо”.¹⁸*

Эндээс үзвэл алс холоос ирсэн өөрийнх нь ид шидэт түүхийг итгэж чадахгүй байгаа олон зонд үнэн түүхээ, ид шидээ үзүүлж итгүүлж, бахархуулахын тул ийнхүү “үхрийн эвэр бомбоо”, “ширээдэсний улаан цог” мэтийг нэхсэн хэрэг ажээ. *Ер нь бөөгийн онгод ийн ид шид, гайхамшигийг үзүүлэн элдвээр аашлах нь хурсан олонд өөрийн ид чадал, сүр хүчнийг үзүүлэн тунхах учир зорилготой байдаг гэмээр билээ.*

Харин эртний баларлаг шинжээ хадгалсан хуулар, духа онгодын тамалгад:

*Ёо-ёо... хүнээ маххан хүнэс-мни
Хүзүү толагай токлаам-мни
Хөө-ёо-ёо... нохойн арсан нөмөргэ-мни (нобши-мни)
Нойтан чусан умда-мни, ёо ёо ёо¹⁹*

гэхчлэн тамалдгаас үзвэл, ерийн хүний биед багтаж шингэхгүй их хүчит онгод учраас хүнд хүчир өвчин туссан адил ёолж тамалдаг бөгөөд зарим эртний догшин онгодыг хүмүүн тайлга хийж тахиж байх баларлаг цаг үеийн онгод байж болох юм.

Эцэст энэ бүхнийг дүгнэж үзвэл, “угийн их гарбали, унгийн их шүтээн болсон” онгод тэнгэр маань “ханат гэрийн хоймор, халуун голомтын захад” бууж, үр хойчис болсон “бяцхан бүжин зулзаганууд”, хонгор улаан зоньхоо амар мэндийг асууж, өгцөө авцаа сүлжилдсэн энэ орчлонд хүнийх нь амин насыг бөхөлж, мал сүргийг нь бүрэн бүтэн байлгахын төлөөнөө аагтай улаан шаргал цай, амтат бараан ундаа, мэндийн улаан (шар, ногоон) тамхи гурвыг голчлон нэхэх бөгөөд үүнийг дагалдан бөө мөргөлийн аман яруу найргийн нэгэн төрөл зүйл болох нэхэл үг хэмээх уран яруу шүлгийг шүлэглэн хэлдэг байна. Энэ гурваас гадна

¹⁸ Галзууд омогт Ч.Цэрэн заарингаас тэмдэглэн авав (Дорнод аймаг, Баян-Уул сум, 1995 оны 6-р сарын 18).

¹⁹ С.Дулам, Дархад бөөгийн уламжлал. Латин галиг, удиртгал тайлбартай, Эрхэлсэн О.Пүрэв, МУИС-ийн хэвлэл, Улаанбаатар, 1992, 200 т. х.

тухайн угсаатны бөлгийн эрхэлдэг аж ахуй, аж амьдралын хэвшил заншил, соёл, түүхтэй холбоотой, бүр заримдаа тухайн бодгалийн хувийн намтар паянтай холбоотой идээ ундаа, эд өлгийн зүйлсийг нэхдэг болох нь тодорхой байна. Харин онгод тэнгэр болсон өвөг дээдсийнхээ ааш араншин, үүх түүхийг сайн мэддэг, юу нэхэж ууж иддэгийг нь анддаггүй гэр удмын хүмүүс нь, эсвэл бөө бөөлүүлж байгаа айл гэрийнхэн дуудах онгодынхоо нэхдэг зүйлсийг урьдчилан бэлтгэсэн байх юмуу урьд өмнө сайн мэддэггүй зүйлсийг гэнэт нэхэж сандаргах болбол бүхий л учир явдлыг үнэн мөнөөр нь, гарцаагүй байдлаар тайлбарлаж, уур хилэнг нь намхраах юмуу дараагийн удаа заавал бэлтгэж бэлэн байлгахаар амалдаг заншилтай байна.